

БАТЛАВ
ХЭСЭГЧИЛСЭН ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН
УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА

Г.БАТТУЛГА

ХИХУГ-ын техникийн нөхцөл олгох ажлын
хэсгийн 2023 оны 03 дугаар сарын 09 –ны
өдрийн хурлаар хэлэлцэж зөвшөөрөв.

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖИЙН ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ.

Дугаар: ТН01/2023

1. Хэрэглэгчийн нэр: "Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны барилга"
2. Барилгын мэдээлэл: "Сүхбаатар дүүргийн 15 дугаар хорооны барилга"
3. Хэрэглэгчийн байршил: Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо

4. Дулааны тооцоот ачаалал:	Нийт	0.026 Гкал/ц
	А.Халаалт	0.026 Гкал/ц
	Б.Хэрэгцээний халуун ус	0.00 Гкал/ц
	В.Салхилуулга	0.00 Гкал/ц

5. Холболтын цэг: Дулааны худгийн /ДХ-4/ Ф100 мм-ийн голчтой шугамаас Ф50 мм-ийн ган хоолой татаж холбоно.

Шугамын даралт, температурын утга:

А.Холболтын цэг дээр байх түрэлт	18 м
Б. Шугамын статик даралт	35 м.у.б
В.Буцах шугамын даралт	3.0 ата
Г.Гадна агаарын тооцоот температур	-39° С
Д.Температурын график	95/70° С

6. Мөрдөж хэрэгжүүлэх хууль, дүрэм журам:

6.1. Эрчим хүчний тухай хууль

6.2. Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолоор батлагдсан "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"

6.3. Эрчим Хүчний Зохицуулах Хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 290 дүгээр тогтоолоор батлагдсан Дулаан дамжуулах, түгээх сүлжээний "Холболтын журам"

6.4. Дулааны сүлжээ БНБД 41.02.13, Дулааны шугам сүлжээ БНБД 3.05.03.95

7. Зураг төсөл, төсөв боловсруулахад тавигдах шаардлага:

Зураг төслийн үндсэн шаардлага.

7.1. "Эрчим хүчний тухай хууль"-ийн 33 дугаар зүйл, "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн 1.3 дахь заалтыг мөрдөж дулааны төв шугам, салаа болон салбар шугамаар хамгаалалтын зурвасын зайг хангаж барилгыг төлөвлөх, шугамын хамгаалалтын зурвас дотор аливаа тохижилт, зам талбай, зогсоол бусад байгууламж төлөвлөхгүй байх.

7.2 Ажлын зураг төсөл боловсруулахдаа Дулааны сүлжээ БНБД 41.02.13, Дулааны шугам сүлжээ БНБД 3.05.03.95 дүрмийн норм стандартын дагуу төлөвлөж, дулааны төв шугамаас Ф50 мм-ийн голчтой ган хоолой, 2 ширхэг бөмбөлгөн хаалтын хамт холбох.

7.3 Дулааны шугам нь авто замтай огтолцсон учир төлөвлөж буй шугамыг нэвтрэх болон ачаалал даах хүчитгэсэн сувагтай байхаар зураг төсөвт тусган хэрэгжүүлэх.

7.4 Дулааны шугаманд агаар гаргах, ус буулгах, буулгасан усыг юүлэх худгийг стандарт хэмжээнд төлөвлөж, хэрэгжүүлэх.

7.5 Гадна дулааны шугам, узелийн тоноглолыг стандарт норм нийцсэн дулаалгын материалаар техник ашиглалтын шаардлагын дагуу дулаалах ажлыг зураг төсөвт тусган хэрэгжүүлэх.

7.6. Дулааны шугамын трассын дагуух, тохижилт, нөхөн сэргээх ажлын зардал болон гадна дулаан хангамжийн систем, узель ба дотор системийн угаалт, шахалтын туршилт тохируулга хийх зардлыг төсөвт тусган хэрэгжүүлэх.

7.7. Стандарт шаардлага хангасан холигч насосны узель суурилуулах.

7.8. Барилгын дотор халаалтын системд балансын хаалт, термостат хаалт суурилуулах

8. Техникийн нөхцөлд тавигдах нэмэлт шаардлага:

8.1. "Эрчим хүчний тухай хууль"-ийн 30 дугаар зүйл 30.1.10, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалтыг мөрдөж хангагч байгууллагын зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжид бусад хэрэглэгчийг холбуулах.

8.2. Дулааны шугам, тоноглол угсрах, тоолуур, хянах хэмжих хэрэгсэл суурилуулах, дулаалга хийхдээ техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдөж ажиллах.

8.3 Хангагч байгууллагаар дулаан хангамжийн шугам сүлжээний угсралт, тохируулгын ажлын явцад хяналт хийлгэн, ил далд ажлын актаар баталгаажуулсан байх.

9. Архивт бүрдүүлэх материал:

9.1. Хянаж батлуулсан гадна дулааны шугамын зураг.

10. Техникийн нөхцөл олгосон үндэслэл:

10.1. Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 6/131 тоот дулааны эрчим хүчээр хангуулах техникийн нөхцөл хүссэн албан тоот

11. Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа:

11.1. Олгосноос хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

12. Техникийн нөхцлийг хүчингүй болгох тохиолдол:

12.1. Техникийн нөхцлийн хугацаа дууссан.

12.2. Техникийн нөхцлийн ачаалал 10-с дээш хувиар өөрчлөгдсөн.

12.3. Энэхүү техникийн нөхцлийн аль нэг заалтыг биелүүлээгүй.

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

ГИШҮҮД:

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЛБАНЫ ДАРГА

ЗАСВАРЫН ШУУРХАЙ БРИГАДЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ГОРИМ ТОХИРУУЛГЫН ИНЖЕНЕР



Г. ОДОНЧОЙЖАВ

Б.ЭРДЭНЭЭ

Б.АМАРСАНАА

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ц.АЛТАНГЭРЭЛ



Г ИХ МЯНГАН ИНЖЕРНЕРЧЛЭЛ ХХК-Д

**НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН
109 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ**

Дамбадаржаа 2, 15 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14061
Утас: 35-74-08

2024. 01. 17 № 03.

танай _____ -ны № _____ -т

Г Хүсэлт гаргах тухай Г

Манай байгууллагын зүгээс 1461801757 тоот газар дээгүүр 15-р хорооны барилга руу холбогдох дулааны шугам явуулахад татгалзах зүйлгүй болно.

ЭРХЛЭГЧ *С. Мөнхтүүл* Г. МӨНХТУУЛ

